



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

ЁНТАН ЗУУХ ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУНД
СУДАЛГАА ЯВУУЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Эдийн Засаг, нийгмийн 2009 оны зорилтын 4.5 дахь заалт, Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээ, Нийслэлийн Агаарын чанарын албаны 2009 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Гэр хорооллын халаалтын хэв маягийг сайжруулах замаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах туршилтын төсөл"-д мониторинг хийх, Ёнтан зуух түлшний ашиглалтын талаар нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, төслийн үр дүнг тодорхойлох үүднээс судалгаа явуулах ажлыг албаны нийт ажилтнууд, "Сонжин-Энержи" ХХК, Байгаль орчин, менежментийн "Эко-Ази" дээд сургуультай хамтран зохион байгуулсугай.

Хоёр. Судалгааны ажлын дүнг нэгтгэн төслийн үр дүнд дүгнэлт хийж, Ёнтан зуухны ашиглалтын талаар нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж ажиллахыг мэргэжилтэн Ц. Мөнхбатад үүрэг болгосугай.

Гурав. Судалгааны ажилд шаардагдах нийт зардлын 50 хувь болох 591000 / таван зуун ерэн нэгэн мянган/, төгрөгийг гэрээт ажлын цалингаас гаргахыг нягтлан бодогч З. Сэргэлэнд зөвшөөрсүгэй.



ДАРГА

Б.ИНЖИННАШ

My Documents tuchaal

0500033